



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.20 № УАЭ-САГ/2013/67/СТГА-ТӨВТ 01/44
Төлбөр барагдуулах тухай

“Цагаан шонхор” ТӨААТҮГ-ын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн Санхүүгийн тайланд аудит хийх явцад анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 98,253.00 төгрөгийн гүйлгээ хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын”-ын 2.1.1-д “Төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй алдаа, зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавина” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн 98,253.00 төгрөгийг УАГ-ын Төрийн сан банкин дахь улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2013 оны 5 дугаар сарын 01-ний дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, 2013 оны 5 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг “Цагааншонхор” ТӨААТҮГ-ын захирал Т.Батболд, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор

“Си Эс Ай Аудит” ХХК-ны захирал

М.Сэвжидмаа




АКТ

ЗӨВШӨӨРСӨН:

“Цагааншонхор” ТӨААТҮГ-ын захирал
Т.Батболд

ерөнхий нягтлан бодогч
Ц.Цэнгэлмаа



070128